



СЭЛЭНГЭ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНД

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2020.07.30 №2020/04-НВ-19
танай -ны № -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Сэлэнгэ аймгийн Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Сэлэнгэ аймгийн Ардчилсан намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт


Сэлэнгэ аймгийн Ардчилсан намын хорооны Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцооор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сэлэнгэ аймгийн Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр / ...14 хуудас /-ийг хавсаргав.

Хувийг: Сэлэнгэ аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА





СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 он



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020

4317143098
МЮА0065 9055436

ТОВЬЁОГ

➤ НЭГ. ХУВЬ ХҮН, НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

- 1.1 Өрсөлдөх чадвартай боловсрол
- 1.2 Эрүүл мэндийн үйлчилгээ
- 1.3 Хүн амын өсөлт, хөгжил
- 1.4 Ажлын байр, хөдөлмөр эрхлэлт
- 1.5 Нийгмийн хамгаалал
- 1.6 Соёл, урлаг, спорт

➤ ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

- 2.1 Хямралыг боломж, боломжийг өсөлт
- 2.2 Өсөлтийн бодлого
- 2.3 Хил орчмын бодлого
- 2.4 Жижиг дунд бизнес, бизнесийн дархлаа
- 2.5 Төсөв, санхүү, татварын бодлого
- 2.6 Хөдөлмөрийн зах зээл
- 2.7 Төрөлжилтийн бодлого
- 2.8 Үйлдвэрлэл
- 2.9 Дэд бүтэц, барилга
- 2.10 Барилгын салбар
- 2.11 Эрдэс баялгийн салбар
- 2.12 Аялал жуулчлал
- 2.13 Шинжлэх ухаан технологи, мэдээлэл, харилцаа
- 2.14 Эрчим хүч

➤ ГУРАВ. ОРОН НУТГИЙН БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ

- 3.1 Бүсчилсэн хөгжил
- 3.2 Орон нутгийн хөгжил
- 3.3 “Шинэ хөдөө” хөтөлбөр
- 3.4 Бэлчээр ашиглалт
- 3.5 Газар тариалан
- 3.6 Мал аж ахуй

➤ ДӨРӨВ. ХАРИУЦЛАГАТАЙ СЭЛЭНГЭ

➤ ТАВ. АЮУЛГҮЙ АМГАЛАН СЭЛЭНГЭЧҮҮД

➤ ЗУРГАА. ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙDAL



МӨРИЙН ХӨТӨЛБӨР

УРИА: ӨРХИЙН ӨСӨЛТӨӨС СЭЛЭНГИЙН ХӨГЖИЛ


Монгол Улсын тусгаар тогтолц, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, нутгийн удирдлага, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд:

Сэлэнгэ аймгийн иргэн бурийг хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, ардчилсан Монгол Улсаа хөгжүүлэхийг **ЭРХЭМ ЗОРИЛГО** болгож:

- Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах хувь хүний эрх чөлөө;
- Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглал;
- Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн үнэт зүйлээ болгон тунхагласан СЭЛЭНГЭ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМ 2020-2024 оны орон нутгийн ИТХ-ын сонгуульд **“ӨРХИЙГ ДЭМЖСЭН – ӨСӨЛТИЙН БОДЛОГО”** хэмээх 6 бүлэг, 25 дэд сэдэв, 224 заалт бүхий мөрийн хөтөлбөрөө Та бүхэндээ толилуулж байна.



НЭГ. ХУВЬ ХҮН, НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ



4317143998

МОА0065-0055436

1.1 Өрсөлдөх чадвартай боловсрол

- 1.1.1 Хүүхэд бүрийг хөгжүүлж, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 1.1.2 Гадаадын их дээд сургуульд жил бүр 100-аас доошгүй шилдэг сурагчдыг оюутны тэтгэлгээр суралцах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.
- 1.1.3 Сүхбаатар, Мандал, Шаамар сумдын мэргэжлийн боловсролын сургуулиудад хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцсэн нарийн мэргэжлийн шинэ анги нээж, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх асуудлыг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 1.1.4 Хүүхэд залуучуудыг хөгжүүлэх “СЭЛЭНГЭ STEAM” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. /Шинжлэх ухаан, технологи, инженер, урлаг, математик хөгжил/
- 1.1.5 Сургууль, цэцэрлэгийн удирдлагыг мэргэшсэн тогтвортой, улс төрөөс хараат бус байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.1.6 Тусгай хэрэгцээт /хөгжлийн бэрхшээлтэй/ хүүхэд, иргэдийг дохионы хэлний сургалтад хамруулах асуудлыг бодлогоор дэмжиж, нийгмийн баталгааг хангана.
- 1.1.7 Багш нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, давтан сургаж, “Шинэ Багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.1.8 Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын багш, эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилтан нарын мэргэжил мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор гадаадын түвш орнуудтай хамтарч ажиллана.
- 1.1.9 Сэлэнгэ аймгийн хүүхэд залуучуудыг Англи, Орос, Хятад хэлний боловсрол олгох сургалтад хамруулах ажлыг зохион байгуулна.
- 1.1.10 Сэлэнгэ аймагт ХАА-ийн чиглэлийн их дээд сургуулийн салбарыг нээж сумдын болон бус нутагтаа хөдөө аж ахуйн болон инженер техникийн ажилтнаар хангаж ажиллах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.1.11 Аймаг орон нутгийн эрэлтэд сууринсан инженер, техникч, технологич, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, маркетингийн мэргэжилтнийг бэлтгэхэд бодлогоор дэмжинэ.
- 1.1.12 Иргэний боловсролыг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ.
- 1.1.13 Иргэдийн цахим боловсролыг дэмжих төвүүдийг байгуулна.

1.2. Эрүүл мэндийн үйлчилгээ

- 1.2.1 Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулна.
- 1.2.2 Аймгийн эрүүл мэндийн байгууллагын тусlamж үйлчилгээг түргэн шуурхай чанар хүртээмжтэй, ил тод, ёс зүйтэй, иргэддээ ээлтэй болгоно.



- 1.2.3 Хорт хавдрын шалтгаант нас бааралтыг бууруулж, эрт илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний чанарыг сайжруулах зорилт тавьж ажиллана.
- 1.2.4 Сэлэнгэ аймгийн хэмжээнд хүүхдийн эмнэлгийн хүчин чадлыг нэмэгдүүлж, Сүхбаатар, Мандал, Сайхан сумын орчмын байгалийн үзэсгэлэнт газарт сувиллыг шинээр барьж, ашиглалт оруулах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.2.5 Иргэдийг насын бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах ажлыг зохион байгуулна.
- 1.2.6 Архидалт, хар тамхи, мансууруулах бодист донтох, амиа хорлолтын шалтгаан, сэтгэл зүйн өвчлөлийг эрт илрүүлэх тасгийн үйл ажиллагааг өргөжүүлж, сайжруулахад бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.2.7 Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний зохион байгуулалтыг шинэчилж, материаллаг баазыг бэхжүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг оновчтой зохион байгуулж, үр дүнг тооцдог болгоход онцгой анхаарч ажиллана.
- 1.2.8 Тэтгэвэр тогтоолгосон ахмад эмч, сувилагч нарыг эрүүл мэндийн байгууллагад зөвлөхөөр ажиллуулах боломжийг бүрдүүлж, бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.2.9 Эмчийн чадавх, эмчилгээний үр дүнг үнэлэх цахим систем ажиллуулж, өрсөлдөөнд суурилсан тусламж үйлчилгээг үзүүлэхэд бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.2.10 Уламжлалт анагаах ухааны өв санд суурилж, уламжлалт эмчилгээ, үйлчилгээний брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.2.11 Эрүүл мэндийн даатгалын цахим картыг нэвтрүүлнэ.
- 1.2.12 Эмийн найрлагад ордог амьтан, ургамал, эрдсийн нөөцийг хамгаалж, үржүүлэх, тарих үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.
- 1.2.13 Эмийн хэрэглээ, эрүүл аюулгүй байдлын хяналтыг сайжруулахад холбогдох байгууллагатай хамтран ажиллана.
- 1.2.14 Аймгийн хэмжээнд нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтнуудыг тогтвортой суурьшилтай ажиллах нөхцөл бололцоогоор хангаж ажиллана.

1.3. Хүн амын өсөлт, хөгжил

- 1.3.1 Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн өмнөх насын хүүхдийг хүмүүжүүлэх бодлого, хүүхдийг гэр бүлийнхээ орчинд, ээж аавтайгаа хамт хүмүүжиж төлөвших хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлж, дэмжиж ажиллана.
- 1.3.2 Гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо хамтаяа сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.3.3 Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-т "...газрын хэвллийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ" гэсний дагуу Сэлэнгэ аймгийн өрхийн бизнес, санхүүг дэмжсэн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх саналыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.



- 1.3.4 Аймаг сумын төвд хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.3.5 Сэлэнгэ аймгийн сумдад гэр хорооллын дахин төлөвлөлтийг ипотекийн зээлтэй уялдуулан үе шаттай хэрэгжүүлнэ.
- 1.3.6 Орон нутгийн иргэдээ зээлийн хөнгөлөлттэй нөхцөлөөр хувийн орон сууцтай болгох асуудлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.3.7 Аймгийн хэмжээнд залуу гэр бүл, гэр хорооллын айл өрхүүд, бусад зорилтот бүлгийн өрхийг турээсийн орон сууцаар хангах ажлыг бодлогоор дэмжинэ.
- 1.3.8 Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 1.3.9 Гэр бүлийн бат бэх байдлыг дэмжиж гэр бүл–нөхөн үржихүйн боловсролыг дээшлүүлж, өрх толгойлсон эх /ганц бие эцэг/, хүүхдийг эрсдэлээс хамгаалах нөхцөлийг сайжруулна.
- 1.3.10 Жендерт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхал, бэлгийн дарамтыг арилгах санал санаачилгыг дэмжиж ажиллана.

1.4. Ажлын байр, хөдөлмөр эрхлэлт

- 1.4.1 Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.
- 1.4.2 Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлтийн судалгааны чанарыг сайжруулж, хэрэгцээтэй байгаа ажил, мэргэжлийг эдийн засгийн салбар, ажил мэргэжлээр нарийвчлан гаргаж, их дээд сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын элсэлттэй нягт уялдуулна.
- 1.4.3 Хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэр (цагийн ажил, аутсорсинг, сүлжээний борлуулалт, ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ г.м.)-ийг хүлээн зөвшөөрнө.
- 1.4.4 Орон нутагт гарааны бизнес буюу старт-апыг хөгжүүлэх экосистем (санхүүжилт, сургалт, мэдээлэл, г.м.)-ийг бүрдүүлнэ.
- 1.4.5 Гарааны бизнес, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.

1.5. Нийгмийн хамгаалал

- 1.5.1 Нийгмийн хамгааллын зорилтот бүлэгт чиглэсэн оновчтой бодлого хэрэгжүүлж, халамжийг шаардлагатай өрх, иргэд рүү төвлөрүүлнэ.
- 1.5.2 Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, сайн дурын даатгуулагчдын тоог нэмэгдүүлнэ.
- 1.5.3 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж, асрамжийн үйлчилгээг төрөлжүүлж ажиллуулна.
- 1.5.4 Аймгийн ахмадын сувиллуудын нөхцөл боломжийг сайжруулж, ахмадын сувиллыг нэмэгдүүлэхэд хувийн хэвшлийн үүсгэл санаачилгыг дэмжинэ.
- 1.5.5 Нийгмийн халамжийн салбарт сайн дурын ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.5.6 Иргэд, малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангахад онцгой анхаарч ажиллана.



1.6. Соёл, урлаг, спорт

- 1.6.1 Уламжлалт өв соёлоо бодлогоор дэмжин соёлын өвийг тоон системд хөрвүүлэн хадгалж, олны хүртээл болгох ажлыг эхлүүлнэ.
- 1.6.2 Аймгийнхаа соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түүнийг хамгаалан цуглуулагч, тээн уламжлагч нарыг сурталчлан дэмжинэ.
- 1.6.3 Археологийн болон түүх соёлын дурсгалт газрын бүртгэл, хамгаалалтыг сайжруулна.
- 1.6.4 Мэргэжлийн урлагийн байгууллага, залуу уран бүтээлчдийн уран бүтээлээ олны хүртээл болгох, ур чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.6.5 Сайн дурын уран сайханчид болон урлагийн холбоодын үүсгэл санаачилгыг дэмжинэ.
- 1.6.6 Үндэсний өв соёл, зан заншлыг сэргээн хөгжүүлэх, сурталчилж өвлүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн үндэстэн, ястны язгуур урлагийн наадмыг зохион байгуулж ардын авьяастнуудыг тодруулна.
- 1.6.7 Түүх, соёлын агуулга бүхий контентыг хөгжүүлж, үзэгчдэд хүртээл болгох ажлыг зохион байгуулна.
- 1.6.8 Сэлэнгэ аймгийн биеийн тамир, спортын салбарт аюулгүй ажиллагааны талаар шаардлагатай стандартуудыг нэвтрүүлж ажиллана.
- 1.6.9 Спорт цогцолбор, усан бассейн, сургалтын төв, чөлөөт цагийн үйлчилгээ үзүүлэх барилга байгууламж, дэд бүтцийг бий болгох төслүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
- 1.6.10 Спортын олон улсын хэмжээний томоохон арга хэмжээ, фестиваль, уралдаан, тэмцээнийг зохион байгуулах, оролцоход бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.
- 1.6.11 Эрүүл, идэвхтэй аж төрөх талаар сургалт, сурталчилгааг сайжруулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 1.6.12 Их спортыг дэмжин, спорт клубийг амжилтаар нь дэмжих бодлого баримтална.
- 1.6.13 Аймгийн хэмжээний томоохон суурин газруудад дугуйн зам барина.
- 1.6.14 Бясалгал, хийн дасгал, нийтийн бүжиг, иог, чөлөөт цагийн клубуудын үйл ажиллагааг дэмжинэ.
- 1.6.15 Сүхбаатар, Мандал, Сайхан суманд хүүхэд залуучуудын спорт соёл амралтын хүрээлэн барих ажлыг судалж, санхүүжилтийг холбогдох шатны төсөвт тусгуулж, хэрэгжүүлнэ.
- 1.6.16 Сүхбаатар, Мандал суманд орчин үеийн шийдэлтэй стандартад нийцсэн хөл бөмбөгийн талбай, Ерөө сумын Бугант тосгонд хоккейн талбай, бусад сумдын онцлогт тохирсон спортын байгууламж барих санаачилга гарган, санхүүжилтийг улс, аймгийн төсөвт тусгуулан, хэрэгжүүлнэ.

ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

2.1. Хямралыг боломж, боломжийг өсөлт

Дэлхийн нийтийг хамарсан (КОВИД-19) цар тахлын тархалтаас шалтгаалж олон улсад эдийн засгийн түүхэнд байгаагүй маш ноцтой байдал үүссэн ба



дэлхийн эдийн засаг 2020-2021 онд уналтад орох төлөв байдлыг олон улсын байгууллагуудаас 3 дугаар сард гаргасан.

Монгол Улсын эдийн засгийн гол бүтээгдэхүүн болох зэс, нүүрсний үнэ мөн уналтад орсон ба Улсын Онцгой комиссоос 2020 оны 1 дүгээр сараас авч хэрэгжүүлсэн урт хугацааны гамшгийн өндөржүүлсэн бэлэн байдлаас шалтгаалж худалдаа эрхлэгчид болон үйлдвэр үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийн орлого их хэмжээгээр тасалдаад байна.

Үүнээс үүдэж арилжааны банкуудаас авсан зээлийн эргэн төлөлт буурснаас цаашид чанаргүй зээлийн хувь хэмжээ өсөх хандлагатай байгаа нь банкуудын үйл ажиллагаанд нөлөөлж, санхүүгийн системд савлагаа үүсгэнээр эдийн засаг бүхэлдээ доголдох ноцтой эрсдэлтэй тулгараад байна.

Иймд ажлын байрыг хадгалах, эдийн засгийг эрчимжүүлэх, онцгой үеийн хөтөлбөрийг нэн даруй боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага үүсээд байгаа тул ажлын байрыг хадгалж, иргэн, бизнесээ дэмжсэн аймгийн богино хугацааны тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ. Үүнд:

- 2.1.1 Аймгийн төсвийн тэвчиж болох зардлыг хязгаарлана.
- 2.1.2 Үр ашиг муутай ажиллаж байгаа орон нутгийн өмчт үйлдвэрийн газруудыг үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр нэгтгэж, шинэчлэн зохион байгуулна.
- 2.1.3 Төсвийн хэмнэгдсэн зардлаар ажлын байр нэмэгдүүлэх, төв суурин газруудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, цахилгаан, дулаан, цэвэр усаар хангач байгууллагуудын тасралтгүй, найдвартай ажиллагааг бүрдүүлэх бодлого баримтлан ажиллана.
- 2.1.4 “Сэлэнгэ-Энерго”, “Урсгал-Ус”, “Гавшгай-Ус”, “Цант-Орхон” зэрэг орон нутгийн өмчт үйлдвэрийн газруудын бүтэц, менежмент, удирдлага зохион байгуулалт, технологийг сайжруулж хүний нөөц, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.1.5 Эрчим хүчиний үнэ тарифыг эргэн харж, судалгаа шинжилгээнд тулгуурлан бодитойгоор тогтооно.
- 2.1.6 Хямрал хүндрэлийг хохирол багатай даван туулахад идэвх санаачилга гарган ажиллаж байгаа иргэн, аж ахуй нэгжийг дэмжиж, хамтран ажиллана.
- 2.1.7 Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд дотоод орон нутгийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг өргөнөөр хэрэглэх журам боловсруулж хэрэгжүүлнэ.
- 2.1.8 Аймгийн хэмжээнд “Таниас худалдан авья” хөдөлгөөнийг өрнүүлж жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжинэ.
- 2.1.9 Үр тариа, төмс хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ, зөгийн бал зэрэг бүтээгдэхүүнүүдийг зах зээлд борлуулахад дэмжиж ажиллана.
- 2.1.10 Малын өвөлжилтөд онцгой анхаарч өвс, тэжээлийн хомсдолоос сэргийлэн тэжээлийн нөөц бүрдүүлнэ.
- 2.1.11 Эрүүл мэнд, боловсролын байгууллагуудын тогтвортой ажиллах нөхцөл боломжийг хангаж ажиллана.



2.2. Өсөлтийн бодлого


- 2.2.1 Аймагтаа засаглалын зөв механизмыг бүрдүүлж, мөчлөг дагасан сонгуулийн бодлогоос татгалзаж хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж, төрийн албаны мерит зарчмыг баримтална.
- 2.2.2 Байгалийн нөөцийн өгөөжийг иргэдийн аж байдлыг сайжруулах, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн бүтээн байгуулалт болон орон нутгийн эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжих тогтвортой олон тулгуурт суурь бий болгоход чиглүүлэх бодлого баримтална.
- 2.2.3 Орон нутагт ажиллах хүчийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр олноор бий болгохыг нэн тэргүүний зорилт гэж үзэн 3000-аас доошгүй шинэ ажлын байрыг бий болгох бүтээн байгуулалт, бизнесийн төслүүдийг санаачилсан гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдыг бүх талаар дэмжиж ажиллана.

2.3. Хил орчмын бодлого

- 2.3.1 Алтанбулаг чөлөөт бүсэд бизнес инкубатор төв байгуулж, гадаад худалдааны үйл ажиллагаа эрхлэгчдийг бодлого зохион байгуулалтаар дэмжинэ.
- 2.3.2 Хилийн худалдаа эрхлэгчид, зорчигчдын ая тухтай байдлыг хангаж зориулалтын зорчих хэсэг, зам талбай, ариун цэврийн байгууламж, бараа бүтээгдэхүүнээ хадгалах, борлуулах зориулалтын агуулах, барилга байгууламжийг барих ажлыг эхлүүлнэ.
- 2.3.3 Хил орчимд банк, санхүү, даатгал, тээвэр зууч, цахим мэдээлэл лавлагаа, эрүүл мэндийн анхан шатны тусlamж, үйлчилгээний үйл ажиллагааг сайжруулж төрийн үйлчилгээг, иргэдэд ойртуулна.

2.4. Жижиг дунд бизнес, бизнесийн дархлаа

- 2.4.1 Жижиг дунд бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, гарцыг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллийн сан үүсгэж, гарааны бизнесийг бодлогоор дэмжин, бүтээгдэхүүн үйлчилгээг мэдээллийн санд байршуулна.
- 2.4.2 Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл, баялаг бүтээгчдийг дэмжих орон нутгийн бизнес, брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилгоор “СЭЛЭНГЭ ХӨГЖИЛ” ОНӨААТҮГ-ыг байгуулна.
- 2.4.3 Төрийн албанаас бизнесийн салбарт шилжсэн баялаг бүтээгч иргэдийнхээ бизнес эрхлэлтийг бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.
- 2.4.4 Бизнест учирдаг авлигын дарамтыг арилгах чиглэлд онцгой анхаарч, технологийн дэвшлийг ашиглах замаар авлигыг мэдээлэх, илрүүлэх боломжийг бүрдүүлж ажиллана.
- 2.4.5 Эдийн засгийн түншлэл, бус нутгийн чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулж, гадаад худалдааг хөгжүүлнэ.
- 2.4.6 Гадаад, дотоодын хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, хамтран ажиллана.
- 2.4.7 Төрийн зүгээс бизнес эрхлэгчдэд үзүүлж буй хүнд суртал, дарамтыг арилгаж, татвар төлөгч аж ахуй нэгжүүддээ үйлчилдэг, зөвлөдөг болгоно.



2.5. Төсөв, санхүү, татварын бодлого

- 2.5.1 Орон нутгийн төсвийн зардлыг ач холбогдол, үр өгөөжөөр нь эрэмбэлэх зарчимд шилжиж, үр ашигтай хуваарилалтын бодлого хэрэгжүүлнэ.
- 2.5.2 Орон нутгийн үйлдвэрлэгчдийнхээ бүтээгдэхүүнийг худалдан авах хандлагыг бий болгож мөнгөн гүйлгээг нутагтаа авч үлдэх бодлого баримтална.
- 2.5.3 Хуримтлалыг бий болгох сургалт мэдээллийн бодлогыг хэрэгжүүлж иргэдийн банкин дахь хадгаламжийн хэмжээг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.5.4 Татварын байцаагч, иргэн, аж ахуй нэгж, байгууллагын харилцан уялдаа холбоог сайжруулан, татварын зөвлөгөө өгдөг, хуулийг дээдэлдэг, бизнесийг дэмждэг чиглэлийг баримтална.
- 2.5.5 Иргэн, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн өгөөжтэй санхүүгийн зуучлалыг хөгжүүлэхэд бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.5.6 Аймгийн хэмжээнд үнэт цаасны брокерын үйл ажиллагааг тогтвортой ажиллуулахыг дэмжинэ.

2.6. Хөдөлмөрийн зах зээл

- 2.6.1 Сэлэнгэ аймгийн хэмжээнд ядуурлын түвшнийг улсын дунджаас бууруулах үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлнэ. /2020 оны улсын дундаж түвшин 28%, Сэлэнгэ аймаг 34,5%/
- 2.6.2 Эрдэс баялаг, малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.6.3 Сэлэнгэ аймагт жуулчид хүлээн авах хүчин чадлыг өсгөж аялал жуулчлалын салбарт ажиллагсдын тоог нэмэгдүүлнэ.
- 2.6.4 Мэргэжилтэй ажиллах хүчин, дээд боловсрол олгох их, дээд, дунд мэргэжлийн сургууль төгсөгчдийг үе шаттайгаар ажлын байраар хангана.

2.7. Төрөлжилтийн бодлого

- 2.7.1 Аймагтаа засаглалын эрүүл орчныг бий болгож, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын итгэл, сонирхол татах орчныг бүрдүүлэх бодлого баримтална.
- 2.7.2 Төрөөс аж үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэхэд баримтлах бодлогын хүрээнд орон нутагтаа томоохон үйлдвэрлэлийн төслүүдийг эхлүүлнэ.
- 2.7.3 Барилгын материалын үйлдвэрлэл, барилга угсралтын компаниудын үйл ажиллагааг дэмжинэ.

2.8. Үйлдвэрлэл

- 2.8.1 Аймаг орон нутагт өрсөлдөх чадвар бүхий түүхий эд, эрдэс баялгийг боловсруулах үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин ажиллана.
- 2.8.2 Эдийн засгаа уул уурхайн салбараас хараат байдлаас гаргах зорилгоор хөнгөн-хүнсний үйлдвэрлэл, аялал жуулчлал, эдийн засгийн бусад салбаруудын өсөлтийг дэмжих бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулж, төрийн захирагааны төв байгууллагад уламжилна.



- 2.8.3 Хөдөө аж ахуйн боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, олон улсын чанар, стандартыг нутагшуулж, экспортлох цогц арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх талаар төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллана.
- 2.8.4 Сэлэнгэ аймагт хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах **бодлогыг** хэрэгжүүлж, "Органик хүнс" хөтөлбөр боловсруулж, мах, сүү, гурил, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг ханган экспортлох бодлого баримтална.
- 2.8.5 Мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудын хүнсний бүтээгдэхүүний лаборатори байгуулахыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.8.6 Орон нутагтаа стратегийн хүнсний бүтээгдэхүүн болох жимс жимсгэнэ, элсэн чихэр, ургамлын тосны хангамжийг нэмэгдүүлэх хувийн хэвшлийн үйлдвэрлэлийн санаачилгыг дэмжинэ.
- 2.8.7 Сэлэнгэ аймагт загас, загасан бүтээгдэхүүн нөөшлөх үйлдвэрийг барьж байгуулах хувийн хэвшил, иргэдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 2.8.8 Импортын хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулахад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- 2.8.9 Хүн амын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг чанартай хүнсээр хүртээмжтэй хангаж, дотоод зах зээл дэх хүнсний нийлүүлэлтийн сүлжээг бий болгож аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлэх замаар найдвартай хүнс нийлүүлэгч аймаг болох бодлого баримтална.
- 2.8.10 Хүнсний ногоо тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, борлуулалтын сүлжээ бий болгох чиглэлээр Солонгос, Япон зэрэг өндөр хөгжилтэй орнуудын туршлагыг орон нутагтаа нутагшуулах ажлыг зохион байгуулна.
- 2.8.11 Төв суурин газрын нийтийн орон сууцны оршин суугчдад хүнсний хэрэгцээгээ хангах, өрхийн орлогоо нэмэгдүүлэх зорилгоор дөрвөн улирлын төвлөрсөн хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж, ногоо тариалах газрын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх бодлого баримтална.
- 2.8.12 Мэдээллийн технологийг ашиглан мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна.
- 2.8.13 Бүх нийтийн хүнсний боловсролыг дээшлүүлэх, хоол хүнс, шим тэжээлийн чанар, аюулгүй байдлыг эрүүл амьдралын зан үйл, хэвшилтэй нягт уялдуулах чиглэлээр аймгийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 2.8.14 Төв суурин газрын хүн амыг эрүүл ахуй, чанарын шаардлагад нийцсэн усаар хангах дэд бүтцийг сайжруулах асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.8.15 Малаас гарч буй түүхий эд болох арьс шир, ноос ноолуурыг боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.8.16 Үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг гаднын байгууллагуудын хөрөнгө оруулалт, зээл, тусlamжид хамруулах бодлого баримтална.
- 2.8.17 Экспортын чиг баримжаатай хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрлэлийн кластерийг аймгийн түвшинд хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.

4317143998
09955436



2.8.18 Орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг төрийн бүх байгууллагууд хэрэглэдэг байх журам тогтоож, бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлэх бодлого баримтална.

2.9. Дэд бүтэц, барилга

- 2.9.1 Эдийн засгийн өсөлтийн суурь болсон дэд бүтэц (зам тээвэр, эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч, усан хангамж, мэдээлэл, харилцаа холбоо)-ийн хөрөнгө оруулалтыг хувийн, төсвийн, болон төр хувийн хэвшлийн түншлэл зэрэг санхүүжилтийн бүхий л төрөл, боломжийг идэвхтэй ашиглана.
- 2.9.2 Аймгийн төв болон томоохон сумдад “Гудамж” төслийг үргэлжлүүлэн, авто замын уулзварыг шинэчлэх ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бодлого баримтална.
- 2.9.3 Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэр дээрх авто замын болон аялал жуулчлалын зориулалттай авто замын сүлжээний танилцуулга гаргана.
- 2.9.4 Гудамж, нийтийн эзэмшлийн талбай, авто замуудыг камержуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.9.5 Шинэ суурьшлын бүс болон сумын төвийн шинэчлэлийн хүрээнд инженерийн шугам сүлжээ, дэд бүтэцтэй барилга байгууламжийг барих ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барьж гүйцэтгэнэ.

2.10. Барилгын салбар

- 2.10.1 Барилгын салбарт ажиллагсдын эрүүл мэнд, санхүүгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.
- 2.10.2 Аймаг сумын төвийн батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу дахин төлөвлөлтийн ажлыг дэмжиж, эрчимжүүлнэ.
- 2.10.3 Барилга, байгууламжийн насжилтыг тогтоож мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж, дахин төлөвлөх ажлыг эхлүүлнэ.
- 2.10.4 Орон нутагт хотжилтыг дэмжих зорилгоор Сүхбаатар, Сайхан, Мандал зэрэг сумдад барилгын материалын жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бодлогоор дэмжинэ.
- 2.10.5 Сэлэнгэ аймагт сургууль, цэцэрлэг, дотуур байр, спорт заал, бассейн, хүүхдийн хөгжлийн төвийн барилга байгууламжид тавигдах нэгдсэн стандарт шаардлагыг мөрдүүлнэ.
- 2.10.6 Барилга байгууламж бүхэнд тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан зам шат бүхий хэрэгсэл суулгана.

2.11. Эрдэс баялгийн салбар

- 2.11.1 Төр, хувийн хэвшлийн түншлэлд түшиглэн ашигт малтмалыг олборлож, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох боломжтой үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих бодлого баримтална.
- 2.11.2 Хариуцлагатай уул уурхайн олон улсын стандарт, шалгуур үзүүлэлтүүдийг иргэн, аж ахуйн нэгж бүр үйл ажиллагаандaa хатуу мөрдөж, ашигласан болон ашиглаж байгаа талбайг хамгаалах, нөхөн сэргээлтийг заавал хийж байх ажлыг хэвшил болгоно.



- 2.11.3 Аюулгүй ажиллагааны хариуцлагыг чангатган уул уурхайн хайгуул болон олборлолт, хаалтын аюулгүйн үйл ажиллагааг зохицуулах хууль журмыг хэрэгжүүлнэ.
- 2.11.4 “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын хүрээнд алтны 998 хууль бус олборлолт, наймааг таслан зогсоох үйл ажиллагааг МОСА0065.0055436 эрчимжүүлнэ.
- 2.11.5 Аймгийн нутаг дэвсгэрт нөхөн сэргээх шаардлагатай газруудад иргэн, аж ахуй нэгж, олон нийтийн оролцоо, олон улсын байгууллагуудтай хамтран ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.11.6 Аймгийн “Уул уурхайн талаар баримтлах бодлого”-ын хүрээнд бичил уурхай эрхлэгчдийг бизнесийн бусад салбарт шилжин ажиллахад нь бодлогоор дэмжиж ажиллана.

2.12. Аялал жуулчлал


- 2.12.1 Спортын, эрүүл мэндийн, эко-туризм, ургамал, амьтан судлал, түүх соёлын дурсгалт газруудын судалгаа шинжилгээ экстрем /адал явдалт/ аялал зэрэг аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг дэмжинэ.
- 2.12.2 Аймгийн аялал жуулчлалын талаар баримтлах бодлогын хүрээнд Тур бааз, Тур оператор компаниудын үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, стандартыг мөрдүүлнэ.
- 2.12.3 Орон нутгийн иргэдийн амьдралд сайнаар нөлөөлөх жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх аялал жуулчлалын дэд бүтцэд хийх гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж, хамтран ажиллана.
- 2.12.4 Аялал жуулчлалын салбарт ажиллах хүчний ур чадварыг хөгжүүлэхэд анхаарч, сургалтад хамруулах асуудлыг бодлогоор дэмжинэ.
- 2.12.5 Сэлэнгэ аймагт аялах, жуулчлах эрэлтийг нэмэгдүүлэх, эргэлтийг нь сайжруулах зорилгоор эвент арга хэмжээг зохион байгуулна.
- 2.12.6 Аялал жуулчлалын ложистикийн үйлчилгээг хөгжүүлэхэд төрийн болон хувийн хэвшлийн түншлэлээр хамтран ажиллана.
- 2.12.7 Хил орчмын аялал жуулчлалыг ахисан түвшинд хүргэх санаачилга гарган ажиллана.

2.13. Шинжлэх ухаан технологи, мэдээлэл, харилцаа

- 2.13.1 Орон нутагт өндөр хурдны интернэтийн сүлжээг өргөтгөж, 5G технологийг нэвтрүүлэх боломжийг судалж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 2.13.2 Айл өрхийн хаягжилтыг сайжруулан шуудан хүргэлтийн системийг боловсронгуй болгох бодлого баримтална.
- 2.13.3 Багш нарын цахим боловсролын ур чадварыг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

2.14. Эрчим хүч

- 2.14.1 Сүхбаатар хотыг цахилгаан эрчим хүчний хоёрдогч эх үүсвэрээр хангах асуудлыг судалж, шийдвэрлэнэ.
- 2.14.2 Сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг барих төр хувийн хэвшлийн түншлэлийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.



2.14.3 Аймгийн төв болон сумдын дулааны станц, шугам сүлжээг шинэчилж, халаах хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

2.14.4 Сумдын дулааны станц, уурын зуухны өмчлөлийн асуудлыг хянаж, үр дүнг тооцон олон нийтэд мэдээлнэ.

2.14.5 "Шинэ зууны малчин" хөтөлбөр хэрэгжүүлж, малчин өрхүүдийг хүчин чадал өндөртэй цахилгаан хэрэгсэл ашиглах боломжоор хангахад бодлогоор дэмжинэ.

4317143998

МО130660055436

ГУРАВ. ОРОН НУТГИЙН БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ

3.1. Бүсчилсэн хөгжил

3.1.1 Орон нутгийн хөгжлийн ялгааг арилгаж, тэнцвэртэй хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ. Аймгийн 5 бүсийн эдийн засгийн өрсөлдөх чадвар, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан бодлогын баримт бичгийг шинэчилнэ.

3.1.2 Бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхдээ хил залгаа аймаг болон хөрш улсуудын зах зээлийн нөхцөл, дотоодын үйлдвэрлэлийн чадавх, дэд бүтцийн боломжид тулгуурлана.

3.2. Орон нутгийн хөгжил

3.2.1 Орон нутгийн аж ахуй нэгж, компаниудын чадавх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх төслүүдийг дэмжинэ.

3.2.2 Мал аж ахуй, газар тариалан, гахай, тахиа, зөгий, загасны аж ахуйд суурилсан орон нутгийн онцлог шинэ брэнд бүтээгдэхүүний бизнес загварыг хөгжүүлнэ.

3.3. "Шинэ хөдөө" хөтөлбөр

3.3.1 Уламжлалт мал, аж ахуйн гаралтай түүхий эд ноос, ноолуур, арьс шир, махыг малчдын оролцоотой анхан шатны түүхий эдийн тортдолгооны цэгт бэлтгэн өндөр түвшний технологийн үйлдвэрт эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, хамтран ажиллана.

3.3.2 Газар тариалангийн үйлдвэрлэлд техникийн шинэчлэл хийж, баталгаат сортын үрийн хангамж, ургамал хөрс хамгаалалт, услалтын систем барих зэрэг агро техникийн цогц арга хэмжээг дэмжинэ.

3.3.3 Төмс, хүнсний ногоо тариалагчдыг хүлэмжээр хангах, борлуулалтыг нэмэгдүүлэх асуудлыг бодлогоор дэмжиж ажиллана.

3.3.4 Сумын төвийг дахин төлөвлөж, ногоон байгууламж, дэд бүтэц, барилга байгууламж бүхий орчин үеийн сууриныг хөгжүүлэх бодлого боловсруулж ажиллана.

3.3.5 Сумын шинэчлэлийн хүрээнд иргэдийн оролцоотой "Шинэ сум" төслийг боловсруулан холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх арга хэмжээ авна.

3.4. Бэлчээр ашиглалт

3.4.1 Малын хөлийн татварын асуудал болон татварын орлогыг тухайн орон нутгийн төсвөөр дамжуулан бэлчээрийн нөхөн сэргээлтэд зориулах санал санаачилга гаргаж, шийдвэрлүүлнэ.



- 3.4.2 Бэлчээр ашиглалтын тухай хууль эрх зүйн орчны хүрээнд аймгийн бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам боловсруулж, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 3.4.3 Малчдын хамтын оролцоонд тулгуурлан аймгийн газар нутгийн 40 орчим хувийг эзэлж байгаа бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг ~~хангаж~~ доройтсон бэлчээрийг сэргээх бодлого хэрэгжүүлнэ.
- 3.4.4 Малчдыг бүлэг, хэсгийн зохион байгуулалтад оруулж, бэлчээрийг гэрээгээр ашиглуулах хэлбэрээр бэлчээрт малын даацыг тохируулан бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурилсан менежментийг нэвтрүүлнэ.
- 3.4.5 Аймгийн хэмжээнд ашиглагдаагүй, ашиглалт багатай бэлчээрийн нөөцийг тогтоож дэд бүтэц, усан хангамжийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- 3.4.6 Ашиглалт багатай, олон жил ашигласнаас хөрсний үржил шим муудсан болон олон жилийн судалгаагаар ургац муу өгдөг тариалангийн талбай болон бусад нөөц газраас олон наст уургийн агууламж өндөртэй тэжээлийн ургамал тариалах зориулалтаар малчдын бүлэг, хоршоонд эзэмшүүлнэ.
- 3.4.7 Малыг тооноос чанарт шилжүүлэх, бэлчээрийн даацыг тохируулж, хамгаалсан малчин өрх, бүлэг, хэсгийг бодлогоор дэмжиж ажиллана.

3.5. Газар тариалан

- 3.5.1 Газар тариалангийн салбарыг хөгжүүлэх бодлогын хүрээнд үрийн аж ахуйн системийг боловсронгуй болгож, хөрс, цаг уурын онцлогт тохирсон, баталгаат сортын үрийн хангамжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 3.5.2 Үр тариа болон ургамал хамгаалах химийн бодис, бордоо, био бэлдмэлийн үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.
- 3.5.3 Аймгийн хэмжээнд усалгаатай газар тариаланг хөгжүүлж, услалтын системийн менежментийг боловсронгуй болгох арга хэмжээ авна.
- 3.5.4 Өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуйг газар тариалангийн үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлнэ.
- 3.5.5 Малын тэжээлийн үйлдвэр байгуулсан иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 3.5.6 Ургамал хамгаалалтын орчин үеийн арга технологийг иж бүрэн хэрэгжүүлж, тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, хортон шавжаас хамгаалах, үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 3.5.7 Дөрвөн улирлын хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.
- 3.5.8 Жимс, жимсгэнийн дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжиж ажиллана.

3.6. Мал аж ахуй


- 3.6.1 Мал аж ахуйн салбарыг эдийн засгийн үр ашигтай, орчин үеийн шинэ технологи, инновацад суурилж, хөгжүүлэх мэдлэг бүхий малчдыг малчин



- бизнесмен болгох замаар тогтвортой орлого бүхий хүчтэй дундаж давхаргыг тэлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.6.2 Малыг тооноос илүү чанарт шилжүүлж, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан мал аж ахуйг хөгжүүлнэ.
- 3.6.3 Аймгийн хэмжээнд малын үүлдэр омог, угшлыг баталгаажуулж төрөлжсөн хэлбэрээр өсгөж үржүүлнэ.
- 3.6.4 Мал аж ахуйн эрүүл бүсийг баталгаажуулж, мал эмнэлгийн үйлчилгээний хуртээмжийг чанартай болгож, хяналтыг сайжруулна.
- 3.6.5 Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх хяналтыг сайжруулж, малыг вакцин, туулгад бүрэн хамруулж, эрүүлжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.6.6 Малаас гарч буй түүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг бодлогоор дэмжинэ.

ДӨРӨВ. ХАРИУЦЛАГАТАЙ СЭЛЭНГЭ


- 4.1 Хууль, шүүхийн байгууллагын албан хаагчдын ёс зүй, зан харилцаанд иргэд, олон нийтийн хяналтыг бий болгох бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.2 Хууль сахиулах байгууллагын үндсэн чиг үүргийг нь иргэдэд аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулалтыг нь иргэний болгох чиглэлийг дэмжиж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд залуусыг гэмт хэрэгт өртөхөөс хамгаалагах арга ажиллагааны хуртээмж, үр нөлөөг нэмэгдүүлнэ.
- 4.3 Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисоос хамааралтай, донтогч болсон иргэнд эмнэлгийн, сэтгэл зүйн болон нийгмийн тусламж, үйлчилгээ үзүүлэх бодлого баримтална.
- 4.4 Нас, хүйс, хөгжлийн ялгаа, бэлгийн чиг баримжаа гэх мэт аливаа төрлийн ялгаварлал, дарамт, хүчирхийллийг гэр булийн орчин, ажлын байр, олон нийтийн бүх орчинд таслан зогсооход чиглэсэн үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 4.5 Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах, ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 4.6 Нийтэд тустай хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг нэмэгдүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, хуртээмжийг сайжруулах бодлого баримтална.
- 4.7 Гамшиг, аюулаас хамгаалах мэргэжлийн байгууллага болон орон нутгийн иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, хамтарч ажиллана.
- 4.8 Гамшигт байдлын болон хямралт байдлын үеийн зохицуулалтыг боловсронгуй болгож, ухаалаг, үр нөлөөтэй, дэс дараатай ажиллах эрсдэлээс хамгаалах материаллаг нөөцийг бүрдүүлнэ.
- 4.9 Аймаг, сумын нутгийн удирдлагын байгууллагын ил тод, нээлттэй байдал, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор цахим ИТХ-ыг жилд 1-ээс доошгүй удаа хийнэ.
- 4.10 Иргэд гарын үсэг цуглуулж, тодорхой асуудлыг хөндөж дэвшүүлсэн тохиолдолд аймаг, сумын ИТХ шууд авч хэлэлцэх боломжийг бий болгоно.



- 4.11 Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэнэ.
- 4.12 Төрийн байгууллагын удирдах албан тушаалтан жил бүр иргэдэд ажлын тайлангийн сонсгол хийх журамд шилжинэ.
- 4.13 Иргэддээ итгэж, анхан шатны нэгж дээрээ асуудлаа шийдвэрлэх зарчимд тулгуурласан нутгийн удирдлагыг бэхжүүлнэ.
- 4.14 Төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
- 4.15 Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуулиудад туссан иргэний оролцоотой хяналт хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 4.16 Орон нутгийн эрэн сурвалжлах сэтгүүл зүй, чөлөөт, олон ургалч хэвлэл мэдээллийн эрх чөлөөний баталгааг дээшлүүлж, хэвлэл мэдээллийн хараат бус бие даасан байдлыг хангана.
- 4.17 Аж ахуй эрхлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд тулгарч буй төрийн байгууллагын хүнд суртлыг арилгана.
- 4.18 Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.
- 4.19 Иргэд, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, цахим өргөдөл, гомдлын 11-11 төвийн үйл ажиллагааг сэргээн ажиллуулна.
- 4.20 Орон нутагт хэрэгжүүлэх аливаа төсөл, хөтөлбөр, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтийн оролцоотой ил тод, нээлттэй болгоно.

ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН СЭЛЭНГЭЧҮҮД

- 5.1 Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг орон нутагт хэрэгжүүлж, аймгийн хил хамгаалах болон шалган нэвтрүүлэх байгууллагуудын хэвийн, тогтвортой үйл ажиллагааг хангана.
- 5.2 ОХУ болон бусад орнуудтай байгуулсан найрсаг хамтын үйл ажиллагааг эрхэмлэж, гадаад харилцааг эдийн засагжуулахад идэвхтэй байр суурь баримтална.
- 5.3 Орон нутгийн иргэдэд суурисан хил хамгаалалтыг бэхжүүлэх, иргэний хяналтын тогтолцоог нэвтрүүлэх замаар хил хамгаалах салбарын хариуцлагыг дээшлүүлэх бодлого баримтална.
- 5.4 Соёлын биет болон биет бус өвийг аймгийн баялагт тооцож холбогдох байгууллагуудад бүртгүүлэх ажлыг зохион байгуулж, үрэгдэж гэмтэх, гадагш алдагдахаас хамгаална.
- 5.5 Төрийн тусгай албан хаагчдын ар гэрийн аюулгүй байдал, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллана.
- 5.6 Иргэн бүрийн аюулгүй байдлаа хангахад хэрэгцээтэй мэдээллийг нийгэмд түгээж, иргэдийн оролцоог дэмжинэ.
- 5.7 Сүхбаатар сумын болон бусад сумдын үерийн хамгаалалтын даланг шинэчилнэ.
- 5.8 Инженерийн шугам сүлжээний аюулгүй байдлын стандартыг хангулна.



ЗУРГАА. ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ

- 6.1 Төрөөс усны талаар баримтлах бодлогын хүрээнд аймгийн уул уурхай, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбар болон төв суурин газрын байгуулалтын бодлогыг тодорхойлоходоо усны нөөц, ашиглалтын бодлогод ~~нийцүүлэх~~
4377143398
55436 зарчмыг баримтална.
- 6.2 Усны хэрэглээ, хяналт, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлж, менежментийг сайжруулан тоолуурын системийг нэвтрүүлнэ.
- 6.3 Аймгийн хэмжээнд хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, усны нөөцийг хурийтлуулах замаар бэлчээр усжуулах, усалгаатай газар тариаланг хөгжүүлнэ.
- 6.4 “Саарал” усыг дахин ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгжийг сурталчлан дэмжиж, хамтран ажиллана.
- 6.5 Бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурисан менежментийг нэвтрүүлж, цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 6.6 Уур амьсгал, цаг уурын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулан, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.
- 6.7 Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг шат дараалан хэрэгжүүлнэ.
- 6.8 Ойжуулах, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, шинэ технологи нэвтрүүлж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 6.9 Ой, рашаан, булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг дэмжинэ.
- 6.10 Ус, хөрс, бэлчээрийг хамгаалах, цөлжилттэй тэмцэх асуудлыг аймгийн нэгдсэн бодлогоор дэмжиж нүүдлийн лабораторийг ажиллуулна.
- 6.11 Аймгийн нутаг дэвсгэрээр урсан өнгөрч буй гол, мөрний гидрологи, гидрометрийн судалгааны мэдээллийн санг үүсгэж, усны барилга байгууламж /гүүр, услалтын систем, далан, суваг... г.м/ барих нөхцөлийг бүрдүүлнэ.
- 6.12 Аж үйлдвэр, хөдөө аж ахуй, уул уурхайн салбарт газрын гүний ус ашиглахыг хязгаарлаж, гадаргын ус ашиглах бодлого хэрэгжүүлнэ.
- 6.13 Орчиндоо ногоон байгууламж нэмэгдүүлсэн болон жимс, жимсгэнийн мод, бут тарьж ургуулах үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.
- 6.14 Сүхбаатар, Мандал зэрэг сумдад ногоон байгууламжийн услалтын системийг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 6.15 Орон нутагт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн байгууллага байгуулах үүсгэл санаачилгыг дэмжинэ.
- 6.16 Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн байнгын өсөлтийг хангасан ногоон эдийн засагт суурисан хөгжилд хүрэх зорилт тавин ажиллана.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО

